

“ЗӨГИЙ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**Нэг: Зөгийн аж ауйн өнөөгийн байдал**

Манай орны хувьд зөгийн аж ахуйн салбар нь 1959 онд ОХУ-ын Улан Үд хотоос 20 бүл зөгийг оруулж ирэн одоогийн Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутагт нутагшуулан, өсгөн үржүүлж эхэлсэнээр өнөөгийн Монгол орны зөгийн аж ахуйн үндэс суурь нь тавигдаж эхэлсэн байна. Өдгөө зөгийн аж ахуй нь үүсэж хөгжөөд 57 гаруй жил болсон хэдий ч ХАА-н салбарт зөгийн аж ахуй нь тодорхой байр суурийг эзлээгүй байгаа нь зөгийн аж ахуйн ач холбогдлын талаар төдийлөн сайн мэдэхгүй байгаатай холбоотой юм. Гэтэл гадны улс орнууд манай орны зөгийн балыг дэлхийн зөгийн балуудтай харьцуулан шинжилж үзээд ашигт чанараар хамгийн өндөрт тооцогдон байгааг хэдийнээ мэдэж монгол зөгийн бал болон бүтээгдэхүүнийг хэрхэн өөрийн оронд гаргах талаар хэдийнээ судлаад эхэлсэн байна.

Дархан-Уул аймгийн Орхон суманд анх зөгийчидийн холбоо 2002 онд 15 өрхийн 30 гаруй гишүүнтэй, 16 бүл зөгийтэй, зөгийчдийн эрх ашгийг хамгаалах, **зөгийн аж ахуйг хөгжүүлэх зорилготой** байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлж байсан.

Сүүлийн жилүүдэд зөгийн аж ахуйн салбар нь эргэн сэргэх хандлагатай болсон бөгөөд төрөөс бодлогоор дэмжиж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар сумын зөгийчидийн холбоо нь эгнээндээ зөгийн аж ахуй эрхлэх 4 хоршоо, 1 дундын хоршоо, 1 компани, 100 гаруй иргэнийг элсүүлэн 700 гаруй бүл зөгийтэй жилдээ дунджаар 10 гаруй тн зөгийн бал хураан авч зах зээлд нийлүүлж байна.

Энэ нь физиологийн нормоор тооцвол нэг хүнд жилд 1,8 кг цэвэр зөгийн бал хэрэглэх гэж үзвэл нийт хүн ам жилийн хэрэгцээ 175,5 тн бал шаардагдана.

Мөн зөгийн балнаас гадна зөгийн цэцгийн тоос, жилий, лав зэргийг хүн амын эмчилгээ гоо сайхны салбарт нийлүүлж байна. Ийнхүү зөгийн аж ахуй нь дахин сэргэн байгаа төдийгүй үүнтэй уялдан зарим сөрөг үр дагаварууд гарах хандлагатай байна. Үүнд мэргэжлийн бус зөгийчид ихээр олшрох, мэргэжлийн бус аргаар эх зөгийг гаргах зэрэг зарим сөрөг дагаварууд гарч байна. Үүнтэй холбогдуулан сумын зөгийчидийн холбоо нь ахмад зөгийчидтэйгээ хамтран, зөгийн аж ахуй эрхлэж байгаа бөгөөд эрхлэх хүсэлтэй зөгийчидэд мэргэжил олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулж мэргэжлийн сертификат олгох, төрийн байгууллагуудтайгаа хамтран мэргэжлийн сургалтуудад зөгийчдийг хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна.

Хоёр: Зөгийн аж ахуйн ач холбогдол

Зөгийн аж ахуйгаас олон төрлийн бүтээгдэхүүн авч хүнс, болон эмчилгээ сувилгаанд ашиглахаас гадна ургамлын тоос хүртээхэд ашигласнаар ургацын 40-50 хувь дээшлүүлж, үр жимс, ногооны чанарт сайн нөлөө үзүүлдэг.

Зөгийн бүтээгдэхүүнийг эрт дээр үеэс хүн төрөлхтөн олон төрлийн өвчнийг анагаах, түүнээс урьдчилан сэргийлэх бие мах бодийг чийрэгжүүлэх зорилгоор хэрэглэж ирсэн. Зөгийн бал сүүнцэрийг эмчилгээний журмаар хэрэглэх нь урт наслах гол үндэс гэж эрдэмтэд баталсан байна. Зөгийн аж ахуйгаас гардаг бал лав, сүүнцэр жилий, тоосомцор хор гэх мэт бүтээгдэхүүн нь хүнс, тэжээл, эмчилгээ сувилгаа, үйлдвэр, хөдөө аж ахуй, сансар судлал зэрэг олон салбарт хэрэглэгдэж байна.

Зөгийн бал эмчилгээний ач холбогдолтойгоос гадна, хоол тэжээлийн чухал бүтээгдэхүүн бөгөөд бие мах бодийг микро элемент, витамин амин хүчлээр хангаж, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн, дотоод шүүрлийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг. Мөн хүний биеийн ерөнхий байдал, зүрхний ажиллагааг сайжруулан ходоодны шүүсний хүчиллэгийг хэвийн болгож цус багадалт, бамбай булчирхайн хордлого, элэгний эдийн нэмтэл, туяаны эмчилгээнд хэрэглэдэг.

Гурав: Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

Төрөөс, хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх, дотоодын эргэлт хэрэгцээнд нийцүүлэх чанар сайтай аюулгүй бүтээгдэхүүн нийлүүлэх, аймгийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зөгийн аж ахуйг хөгжүүлэх, загвар аж ахуй бий болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг дэвшүүлэн тавьсан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндэд чухал хэрэгцээтэй зөгийн бал болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн хэрэгцээг хангах нь тулгамдсан зорилт болж байна.

Зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн улирлын чанартай байдаг боловч өөрийн аймгийн нөхцөлд тохирсон тэсвэртэй найдвартай бүтээгдэхүүн өгдөг үүлдрийн зөгийг үржүүлэх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд зөгийн аж ахуй эрхлэх сонирхол дээшлэж байгаа боловч зөгийн бүлийн олдоц муу, түүнийг эрхлэх дадлага туршлага бага, мэдээллээр хангах ажил хангалтгүйн тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Малын тоо хэт их өсөж, бэлчээрийг хуваарьгүй дур зоргоороо ашигласнаас зөгийн бэлчээр хомсдож байна.

Дээрх хор үр дагаврыг арилган, зөгийн аж ахуйн талаар сургалт, сурталчилгаа хийж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Өрхийн аж ахуйд зөгийн аж ахуй эрхлэж таримал болон бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, эмчилгээ сувилгааны чанартай бүтээгдэхүүнээр өрх гэрийнхээ хэрэгцээг хангах улмаар зах зээлд борлуулах боломж байна.

Зөгийн аж ахуй эрхэлснээр өрсөлдөх чадвартай байгалийн цэвэр бүтээгдэхүүн зөгийн бал үйлдвэрлэж дотоодын зах зээлээс хуурамч бал, гадаадын балыг шахан зайлуулах шаардлагатай байна.

Дөрөв: Хөтөлбөрийн зорилго, зорилт

4.1. Хүн ам өсөн нэмэгдэж байгаа, хүнсний уураг витаминаар баялаг, эмчилгээ сувилгааны чанартай зөгийн бал түүний бусад бүтээгдэхүүнээр хангах, зөгийн аж ахуйг өрхийн болоод загвар аж ахуйн түвшинд хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

4.2. Хөтөлбөрийн зорилгоо биелүүлэхэд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Иргэдийг зөгийн аж ахуй эрхлэх арга барилд сургах, эрдэм шинжилгээний байгууллага эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй хамтарч балт ургамлын судалгаа явуулж нөөцийг тогтоох.

4.2.2. Чанар үр ашиг сайтай шинэ үүлдрийн эх зөгий гарган авах ажлыг эхлүүлэх, эх зөгийний үүлдэр угсааг хадгалан үлдэх, чанарыг сайжруулах.

4.2.3. “Дархан” нэртэй эх зөгийг бий олгож, эко брэнд бүтээгдэхүүнийг гаргах.

Тав. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1. Хөтөлбөрийн 4.2.1 зорилтын хүрээнд:

5.1.1. Зөгийн арчилгаа маллагааны технологи, үржлийн ажлын талаар ард иргэдийн дунд сургалт зохион байгуулах.

5.1.2. Зөгийн үржлийн аж ахуй байгуулж, иргэд аж ахуйн нэгжийг эх зөгийгөөр хангах арга хэмжээг үе шаттайгаар авах.

5.1.3. Зөгийн аж ахуй эрхлэгч өрхүүдэд ойрын бэлчээрийг гэрээгээр ашиглуулах.

5.1.4 Зөгийн аж ахуйгаар мэргэшсэн эмч мэргэжилтнийг давтан сургалтаар бэлтгэх.

5.2. Хөтөлбөрийн 4.2.2 зорилтын хүрээнд:

5.2.1 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид нэг ба олон наст ургамал тариалах. / царгас, хүцэнгэ, наранцэцэг, гурвалжин будаа, хар будаа гэх мэт/

5.2.2 Гадаадаас зөгий оруулж ирэх гэрээ хэлэлцээр байгуулж гаалийн болон нэмүү өртгийн албан татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөх асуудлыг төрөөс бодлогын хэмжээнд дэмжиж ажиллах.

5.2.3 Зөгий үржүүлэгчдэд бага хүүтэй урт хугацаатай зээл олгож дэмжлэг үзүүлэх.

5.2.4. Зөгийн суурьт мал эмнэлэг ариун цэврийн зааврын дагуу төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал цэвэрлэгээг тогтмол хугацаанд хийж, халдварт өвчин гарсан тохиолдолд эмчлэн эрүүлжүүлэх ажлыг богино хугацаанд зохион байгуулах.

5.2.5. Зөгийн бэлчээрийг зүй зохистой ашиглаж түүний нөхөн төлжих боломжийг бүрдүүлэх.

5.3 Хөтөлбөрийн 4.2.3 зорилтын хүрээнд:

5.3.1. Зөгийн балны сав баглаа боодлыг сайжруулах замаар савлагааны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх.

5.3.2. зөгийн аж ахуй эрхлэгчдийн үржлийн ажлыг явуулах хугацааг хэмнэх

5.3.3. Гадаад орноос зөгий импортлох ажлыг тусгай зөвшөөрлийн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

Зургаа: Хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг доорхи үйл ажиллагаанд ашиглана:

6.1. Зөгийн үржлийн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх

6.2 Чанар үр ашиг сайтай шинэ үүлдрийн эх зөгий гарган авах ажлыг эхлүүлэхэд

6.3. Зөгийн зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж худалдан авах

6.4.

Долоо: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Засаг даргын тамгын газар нь:

7.1.1. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган хэрэгжилтэд нь хяналт тавьж байх.

7.1.2. Хөтөлбөрийг дэмжих асуудлыг хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын төсөл, хөтөлбөр, зээл, тусламжид тусган хэрэгжүүлж байх үүргийг холбогдох газар, агентлагийн гадаад хамтын ажиллагааны нэг чиглэл болгон хэрэгжүүлэх.

7.2. Хүнс, хөдөө аж ахуйн газар нь:

7.2.1. Хөтөлбөрийг дэмжих зорилгоор аймгийн төсвөөс гарах хөрөнгийг тусган хурлаар хэлэлцүүлэн батлуулж, аймгийн төсөв, бусад эх үүсвэрээс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж дүнг ИХТ болон Засаг даргын зөвлөл, холбогдох газруудад тайлагнах.

7.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, уялдуулах, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлж, сургалт, үйлчилгээг эрхлэн явуулахад мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах.

7.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын зээл, тусламж, төслийг үр ашигтай ашиглах ажлыг зохион байгуулах.

7.2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хуулийн этгээдийн санал хүсэлтийг хүлээн авч түүний мөрөөр ажил зохион байгуулах, шаардлагатай асуудлыг дээд шатны байгууллагад хэлэлцүүлж, шийдвэрлүүлж байх.

7.3. Сум, багийн Засаг дарга

7.3.1 Сумынхаа зөгийн аж ахуй эрхлэгчдийн судалгааг нарийвчлан гаргаж, бэлчээрийн газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах

7.3.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж, зарцуулалтад нь хяналт тавих;

7.3.5. Хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнгийн тайланг орон нутагт хагас, бүтэн жилээр гарган асуудал хариуцсан ХХААГ-т ирүүлэх.

Найм: Хөтөлбөрийн санхүүжилт

“Зөгий” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

- 8.1. Иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө;
- 8.2. Улсын төсөв;
- 8.3. Орон нутгийн төсөв
- 8.4. Халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан,
- 8.5. Банкны зээл
- 8.6. Гадаадын, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл

Ес : Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Дархан-Уул аймгийн нутагт “Зөгий” дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат: /2017-2020 он/ Орон нутагт сурталчлах, сургалт зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгжүүдэд зөгийн аж ахуйн технологийн мэдлэг олгох, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

2 дугаар үе шат: /2020-2025 он/ Зөгийн аж ахуйн эрхлэгчдийн тоо нэмэгдүүлж, нийт өрхийн 15-аас доошгүй хувийг 15-аас доошгүй бүл зөгийтэй болгон бал үйлдвэрлэлийн хэмжээтн-д хүргэнэ.

Арав: Хөтөлбөрийн үр дүн

- 10.1. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд сум бүрд эх зөгий бойжуулах боломж бүрдэнэ.
- 10.2. Сум бүрээс доошгүй бүл зөгийтэй болно.
- 10.3. Нийт өрхийнхувийг.....бүл зөгийтэй болгожтн буюукг бал үйлдвэрлэж аймгийн хүн амын хэрэгцээнийхувийг хангана.
- 10.4. Зөгий дэд хөтөлбөр хэрэгжснээр иргэд, аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэнэ.
- 10.5. Байгалийн болон таримал ургамлын ургац нэмэгдэж, бэлчээрийн талхлагдал доройтол багасна.
- 10.6. Зөгий үржүүлэх нөөц бүрдэнэ.

**Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
Хүнс, хөдөө аж ахуйн газар**